



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд
суутган тооцох журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, Татварын ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд суутган тооцох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг харьяа татварын албаны дарга нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Татварын орлогын газар /Д.Цогтжаргал/-т даалгасугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гааль, Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/185, А/186 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДЭД ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Татварын ерөнхий газрын даргын
... оны ... сарын ... өдрийн ... дугаар
тушаалын ... дүгээр хавсралт

ТАТВАРЫН ОРЛОГО БҮРТГЭХ, ОРЛОГЫН ДАНСНААС ТАТВАР ХООРОНД СУУТГАН ТООЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татвар төлөгчийн улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын орлогыг Татварын ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу бүртгэх, татварын залруулга, зарлагын гүйлгээний хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу татварыг суутган тооцох, суутган тооцооллын бүртгэлд хяналт тавих харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Татварын орлогын дансыг тухайн төсвийн ангиллын дагуу татварын төрөл тус бүрээр зөвхөн төрийн санд байршуулна.

1.3.Татварын орлого нь дараах бүтэцтэй байна:

1.3.1.Татвар төлөгчийн татварын тайлангаар ногдуулж татварын орлогын дансанд төвлөрүүлсэн орлого;

1.3.2.татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалтын актаар тогтоож төвлөрүүлсэн орлого;

1.3.3.шийтгэлийн хуудсаар ногдуулж төвлөрүүлсэн орлого;

1.3.4.хөрөнгийн бүртгэлд суурилсан ногдлоор төвлөрүүлсэн татварын орлого;

1.3.5.эрх бүхий байгууллагын шийдвэрээр ногдуулж, татварын орлогын дансанд төвлөрүүлсэн орлого;

1.4.Татварын орлогын залруулга гэдэгт татварын орлогын тайлант оны гүйцэтгэлээс хасагдахгүй, санхүүгийн жилийн тухайн төсвийн татварын төрөл болон татвар төлөгч хоорондын орлогын бүртгэлийн өөрчлөлтийг хамааруулна.

1.5.Татварын зарлага гэдэгт төрийн сангийн татварын орлогын данснаас татвар төлөгчийн дансанд, татварын орлогын тайлант оны гүйцэтгэлээс хасаж тооцогдох, санхүүгийн жилд тухайн төсвийн бус татварын төрөл хооронд шилжүүлсэн гүйлгээний бүртгэлийг хамааруулна.

1.6.Цахим төлбөрийн баримтын систем гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-д заасныг ойлгоно.

Хоёр.Татварын орлого бүртгэх

2.1.Татварын алба нь татварын орлогыг татвар төлөгч, татварын төрөл, тайлант хугацаагаар ангилан бүртгэнэ.

2.2.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд татварын орлогыг зөвхөн Татварын албаны төлбөрийн баримтын дугаараар бүртгэнэ.

2.3.Татварын төлбөрийн баримт нь дараах төрөлтэй байна. Үүнд:

2.3.1.төлбөрийн нэхэмжлэх гэж татвар төлөгчийн төлбөл зохих татварын дүнг тусгасан татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас үүссэн төлбөрийн баримтыг;

2.3.2.урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэх гэж татвар төлөгчийн бүртгэлтэй татварын төрөл, тайлант хугацаагаар татварын ногдол, өргүй тохиолдолд татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас үүсгэсэн төлбөрийн баримтыг;

2.3.3.төлбөрийн даалгавар гэж суутгуулан төлдөг татварын төрлөөр татвар төлөгч болон суутган төлөгчийн татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас үүсгэсэн төлбөрийн баримтыг;

2.4.Татварын төлбөрийн баримтад татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, татварын албаны нэр, татварын төрөл, хөрөнгийн дугаар, татварын орлогын данс, төлөх татварын дүнгийн мэдээллийг тусгасан байна.

2.5.Төлбөрийн баримтад суурилсан “Цахим төлбөрийн систем”-ээр дамжуулан татвар төлөгчийн төлсөн татвар нь тухай бүр татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд орлогын гүйлгээ тус бүрээр шууд бүртгэгдэнэ.

2.6.Татвар төлөгчийн “Цахим төлбөрийн систем”-ээр дамжуулаагүй Төрийн сангийн татварын орлогын хаалтын дансанд төлсөн орлогыг холбогдох төсвийн татварын орлогын бүртгэл хариуцсан нэгж татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

2.7.Татварын алба нь татвар төлөгчид гүйлгээ таних дугаар бүхий “Татвар төлсөн баримт”-ыг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас хэвлэн авах боломжоор хангана.

2.8.Холбогдох төсвийн татварын орлогын гүйцэтгэлийг тухайн санхүүгийн жилд төсвийн ангиллын дагуу татварын төрөл тус бүрээр төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн татварын орлогын дүнгээс татварын зарлагын гүйлгээний дүнг хасаж тодорхойлно.

Гурав.Татварын залруулга, зарлага бүртгэх

3.1.Татварын залруулга, зарлагын бүртгэлийг татвар төлөгчийн хүсэлт, татварын албаны шийдвэрээр хэрэгжүүлнэ.

3.2.Зөвхөн тухайн санхүүгийн жилийн татварын орлогын гүйлгээнээс татварын төлбөрийн баримтын дугаарыг үндэслэн залруулга, зарлагын гүйлгээг бүртгэнэ.

3.3.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн орлогын гүйлгээний дүнтэй тэнцүү дүнгээр татварын залруулга, зарлагыг бүртгэнэ.

3.4.Татварын алба нь залруулга, зарлагын гүйлгээг Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.4.1.залруулга, зарлагын гүйлгээний хүсэлтийг татвар төлөгчөөс хүлээн авах;

3.4.2.татвар төлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.4.3.зарлагын гүйлгээний хүсэлтийг холбогдох төсвийн төрийн санд хүргүүлэх;

3.4.4.залруулга, зарлагыг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх.

3.5.Татвар төлөгчийн хүсэлт, татварын албаны шийдвэрийн бүртгэлд орлогын гүйлгээний мэдээлэл, татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, татварын тооцооллын дансны мэдээлэл, татварын төрөл, төлбөрийн баримтын дугаар, шалтгаан, дүн зэрэг мэдээллийг тусгасан байна.

3.6.Татварын алба нь татвар төлөгчийн залруулга, зарлагын гүйлгээний хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

3.7.Татвар төлөгчийн хүсэлтийг татварын алба зөвшөөрсөн бол холбогдох Төрийн санд ажлын 5 хоногт багтаан “Зарлагын гүйлгээний хүсэлт”-ийг хүргүүлнэ.

3.8.Татвар төлөгчийн татварын залруулгын гүйлгээний хүсэлтийг татварын алба шийдвэрлэсэн тухай бүр татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд шууд бүртгэнэ.

3.9.Татварын зарлагыг Төрийн сангийн холбогдох татварын орлогын данснаас зарлагын гүйлгээ гарсан тухай бүр ажлын 5 хоногт багтаан татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

3.10.Татвар төлөгчийн хүсэлтийн шийдвэрлэлт, залруулга, зарлагын гүйлгээний бүртгэлийн мэдээллийг татвар төлөгчид тухай бүр цахимаар, шуудангаар, биечлэн хүргүүлнэ.

Дөрөв.Татварын орлого, залруулга, зарлагын бүртгэлийн хяналт

4.1.Татварын орлого, залруулга, зарлагын бүртгэл, бүртгэлийн хяналтыг холбогдох төсвийн ангиллаар дараах шатлалаар хэрэгжүүлнэ:

4.1.1.улсын төсвийн бүртгэл, хяналтыг Татварын ерөнхий газрын орлогын бүртгэл хариуцсан нэгж;

4.1.2.нийслэлийн төсвийн бүртгэл, хяналтыг Нийслэлийн татварын газрын орлогын бүртгэл хариуцсан нэгж;

4.1.3.аймаг, сумын бүртгэл, хяналтыг аймгийн татварын хэлтсийн орлогын бүртгэл хариуцсан нэгж;

4.1.4.дүүргийн бүртгэл, хяналтыг дүүргийн татварын хэлтсийн орлогын бүртгэл хариуцсан нэгж.

4.2.Татварын орлого, залруулга, зарлагын бүртгэлийн ерөнхий хяналтыг Татварын ерөнхий газрын холбогдох нэгж хэрэгжүүлнэ.

Тав.Татварын суутган тооцооллын бүртгэл

5.1.Татвар төлөгчийн илүү төлсөн татварыг Татварын ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу тухайн хугацаанд төлбөл зохих татварт суутган тооцохдоо дараах зарчмыг баримтална.

5.1.1.татварын илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргасан татвар төлөгчийн татварын илүү төлөлтийг бусад татварын өрд;

5.1.2.татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт;

5.1.3.татвар төлөгч хүсэлтийн дагуу харилцан хамааралтай татвар төлөгчийн татварын өрд.

5.2.Энэ журмын 5.1.3-д заасан харилцан хамаарал бүхий татвар төлөгч гэдэгт Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан этгээдийг хамааруулна.

5.3.Татвар төлөгчийн илүү төлсөн татварыг татварын тайлан, татварын улсын байцаагчийн буцаан олголтын акт, шүүхийн болон эрх бүхий байгууллагын шийдвэр, татвар төлөгчийн цахим төлбөрийн баримтын системээс тодорхойлсон буцаан олговол зохих дүнгээр тус тус тодорхойлно.

5.4.Татвар төлөгч нь илүү төлсөн татварыг суутган тооцох хүсэлтийг харьяалах татварын албанд дор дурдсан хугацаанд хүргүүлнэ. Үүнд:

5.4.1.татварын тайлангаар тодорхойлогдсон илүү төлөлтийг суутган тооцох хүсэлтийг тухайн төрлийн татварын хуульд заасан жилийн эцсийн тайлан хүргүүлснээс хойш дараа оны эхний тайлан хүргүүлэх хүртэлх хугацаанд;

5.4.2.цахим төлбөрийн баримтын системээс тодорхойлогдсон татварын урамшууллыг суутган тооцох хүсэлтийг татвар төлөгч баталгаажуулсны дараа буцаан олгох хүртэлх хугацаанд;

5.4.3.хяналт шалгалтын үр дүнгээр тодорхойлогдох татварын илүү төлөлтийн суутган тооцох хүсэлтийг нөхөн ногдуулалтын актыг татвар төлөгчид гардуулсан тухай бүр тухайн санхүүгийн жилд;

5.4.4.эрх бүхий байгууллагын шийдвэрээр тодорхойлогдсон татварын илүү төлөлтийг суутган тооцох хүсэлтийг холбогдох шийдвэрийг татвар төлөгч хүлээн авсан санхүүгийн жилд.

5.5.Татварын алба энэ журмын 5.4-т заасан татвар төлөгчийн суутган тооцох хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

5.6.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд суутган тооцооллын бүртгэл нь хүсэлтийн шийдвэрлэлтийн хугацаагаар бүртгэгдэнэ.

5.7.Татварын алба нь татварын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлээгүй, илүү төлөлтийн дүн тодорхойлогдоогүй тохиолдолд татвар төлөгчийн суутган тооцооллын хүсэлтийг хүлээн авахгүй.

5.8.Тусгай журмын дагуу буцаан олголт хийгддэг татварын төрлийн хувьд суутган тооцоолол хийхгүй.

5.8.1.Нэмэгдсэн өртгийн албан татвар;

5.8.2.Хөрөнгийн албан татвар;

5.8.3.Төлбөр, хураамж.

5.9.Суутган тооцооллын хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар татвар төлөгчид тухай бүр цахимаар, шуудангаар, биечлэн мэдэгдэнэ.

5.10.Татвар төлөгчийн илүү төлөлтийн суутган тооцооллын бүртгэл, хяналтыг татвар төлөгчийн харьяалагдах татварын албаны орлогын бүртгэл хариуцсан нэгж, татварын албаны татварын суутган тооцооллын нэгдсэн хяналтыг Татварын ерөнхий газрын орлогын чиг үүрэг хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.